



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Ankhubayard@audit.gov.mn">Ankhubayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Sodnomp@audit.gov.mn">Sodnomp@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 116

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Э.ТҮВШИНМӨНХ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдэл 118,016,205.00 / Нэг зуун арван найман сая арван зургаан мянга хоёр зуун таван/ төгрөгийн хөрөнгийн тооллого хийгдээгүй, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр А/01 тушаалаар тооллого хийсэн гэх боловч анхан шатны баримт материалын бүрдэл дутуу байна. байгууллага дансанд бүртгэлтэй 5,280,000.00 /таван сая хоёр зуун наян мянга/ төгрөгийн малыг худалдан борлуулж данс бүртгэлээс хассан байна. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар туслах аж ахуйн малын зах зээлд борлуулах үнэ тогтоосон, тухай үнээр худалдаж борлуулсан эсэх, малын тоо толгой зөрүүтэй тодорхой бус, харилцагч байгууллагуудтай тухай бүр нь тооцоо нийлээгүйгээс авлага, өглөг үүссэн зэрэг зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;"

D:/bichighereg/2022A4toot

006020226

гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, тасалбар болголт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in blue ink over a red official stamp. The stamp is rectangular and contains Mongolian text, including the name 'Д.АНХБАЯР' (D. ANKHBAYAR) and the title 'ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' (Chief Auditor). The signature is written in a cursive style.

Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>106,418,038.00</b>	<b>140,937,382.38</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	30,172.00	22,921,177.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	30,172.00	1,008,577.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	21,912,600.00
3351	Байгууллагаас авах авлага	-	21,912,600.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	103,573,666.00	115,202,005.38
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	9,155,566.00	11,273,998.00
35110	Тусгай зориулалттай материал	9,071,566.00	11,056,998.00
35130	Эм боох материал	84,000.00	217,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	89,138,100.00	103,928,007.38
35410	Бичиг хэргийн материал	620,000.00	784,000.00
35420	Аж ахуйн материал	73,654,886.00	73,904,886.00
35440	Түлш, шатах тослох материал	726,000.00	-
35450	Барилгын засварын материал	1,254,000.00	1,214,000.00
35460	Хүнсний материал	4,874,580.00	15,063,888.00
35470	Бусад хангамжийн материал	8,008,634.00	12,961,233.38
35600	Мал амьтад	5,280,000.00	-
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	2,814,200.00	2,814,200.00
36600	Бусад нөөц	2,814,200.00	2,814,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,289,795,214.59</b>	<b>5,112,164,572.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,289,795,214.59	5,112,164,572.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,810,637,298.29	4,627,144,155.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,624,013,517.00	4,624,013,517.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(241,678,612.05)	(360,746,393.01)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	301,949,208.56	330,158,608.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(76,514,927.24)	(146,847,394.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	266,867,230.45	277,576,120.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87,703,353.16)	(120,802,943.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,019,681.41	27,019,681.41
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,621,137.35)	(24,459,564.99)

39217	Ном	14,305,690.67	21,232,524.42
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>479,157,916.30</b>	<b>485,020,416.38</b>
39301	Програм хангамж	3,154,860.00	7,554,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,406,943.70)	(1,944,443.62)
39303	Бусад биет бус хөрөнгө	477,410,000.00	479,410,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5,396,213,252.59</u></b>	<b><u>5,253,101,954.42</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b><u>7,862,187.81</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>7,862,187.81</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>-</b>	<b>7,862,187.81</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	7,400,097.81
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>-</b>	<b>462,090.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	462,090.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>5,396,213,252.59</u></b>	<b><u>5,245,239,766.61</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,396,213,252.59</b>	<b>5,245,239,766.61</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,256,550,162.42	1,256,550,162.42
51101	Өмч: - төрийн	1256550162.42	1256550162.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,757,784,141.07</b>	<b>2,606,810,655.09</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,757,784,141.07	2,757,784,141.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(150,973,485.98)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,381,878,949.10	1,381,878,949.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>5,396,213,252.59</u></b>	<b><u>5,253,101,954.42</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,899,821,100.00</b>	<b>2,364,115,428.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>155,525,800.00</b>	<b>24,749,365.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>155,525,800.00</b>	<b>24,749,365.13</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,525,800.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	155,525,800.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө		22,818,533.75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал		1,930,831.38
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,744,295,300.00</b>	<b>2,339,366,063.06</b>

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,432,727,500.00	1,986,140,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	496,403,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,936,324,300.00	1,986,140,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	600,000.00	12,953,662.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	12,953,662.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	310,967,800.00	340,272,101.06
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	310,967,800.00	340,272,101.06
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,480,439,098.40</b>	<b>2,515,088,914.17</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,480,439,098.40</b>	<b>2,515,088,914.17</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,310,468,046.30	2,354,332,825.18
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,486,325,677.00	1,517,018,912.82
210101	Үндсэн цалин	958,007,214.00	945,762,945.32
210102	Нэмэгдэл	312,751,882.00	413,891,914.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,264,142.00	41,662,500.00
210104	Урамшуулал	161,302,439.00	115,701,553.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	187,095,258.90	193,430,605.50
210201	Тэтгэврийн даатгал	126,858,609.11	135,262,445.27
210202	Тэтгэмжийн даатгал	15,112,610.41	15,084,733.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,083,588.33	12,812,683.69
210204	Ажилгүйдлийн даатгал	3,003,559.19	2,837,232.81
210205	Эрүүл мэндийн даатгал	30,036,891.86	27,433,510.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	308,162,745.00	338,272,101.06
210301	Гэрэл, цахилгаан	11,330,914.00	14,513,303.06
210302	Түлш, халаалт	278,558,187.00	288,622,385.00
210303	Цэвэр, бохир ус	18,273,644.00	35,136,413.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,890,440.68	8,826,465.50
210401	Бичиг хэрэг	1,931,443.00	3,470,022.00
210402	Тээвэр, шатахуун	1,644,000.00	1,770,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	791,497.00	635,853.50
210404	Ном, хэвлэл	142,600.00	210,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	642,990.00	1,982,030.00

**Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,581,017.00	703,300.00
210408	Бараа материал акталсны зардал	2,156,893.68	54,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,571,014.00</b>	<b>54,812,324.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,495,105.00	1,280,700.00
210502	Хоол, хүнс	44,284,359.00	47,473,474.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,791,550.00	6,058,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,185,925.00</b>	<b>6,528,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	70,000.00
210604	Урсгал засвар	7,185,925.00	6,458,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,166,600.00</b>	<b>454,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,842,600.00	454,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>246,990,385.72</b>	<b>234,990,316.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,360,000.00	1,865,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,409,900.00	3,249,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	241,220,485.72	229,875,766.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>169,971,052.10</b>	<b>160,756,088.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,550,900.00</b>	<b>57,498,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,175,900.00	55,408,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,375,000.00	2,090,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>135,420,152.10</b>	<b>103,256,788.99</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	135,420,152.10	103,256,788.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>500.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>419,382,001.60</b>	<b>(150,973,485.98)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>8,660,000.00</b>	<b>-</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	8,660,000.00	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>668,362,049.57</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	668,362,049.57	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(659,702,049.57)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(240,320,047.97)</b>	<b>(150,973,485.98)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,256,550,162.42	1,381,878,949.10	3,423,936,685.71	6,062,365,797.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,256,550,162.42	1,381,878,949.10	3,423,936,685.71	6,062,365,797.23
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(666,152,544.64)	(666,152,544.64)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,256,550,162.42	1,381,878,949.10	2,757,784,141.07	5,396,213,252.59
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,256,550,162.42	1,381,878,949.10	2,757,784,141.07	5,396,213,252.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,256,550,162.42	1,381,878,949.10	2,757,784,141.07	5,396,213,252.59
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(150,973,485.98)	(150,973,485.98)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,256,550,162.42	1,381,878,949.10	2,606,810,655.09	5,245,239,766.61

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,262,788,911.00</b>	<b>2,344,591,563.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,733,070.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,733,070.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,110,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,110,000.00	
120009	Бусад орлого	11,623,070.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,248,055,841.00</b>	<b>2,344,591,563.06</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,936,324,300.00	1,986,140,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,936,324,300.00	1,986,140,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	600,000.00	18,179,162.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	12,953,662.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,225,500.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	310,967,800.00	340,272,101.06
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	310,967,800.00	340,272,101.06
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	163,741.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	163,741.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,236,687,641.00</b>	<b>2,315,164,973.06</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,236,687,641.00</b>	<b>2,315,164,973.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,066,552,847.90</b>	<b>2,153,508,884.07</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,471,341,816.00</b>	<b>1,510,418,420.01</b>
210101	Үндсэн цалин	940,794,538.00	939,162,452.51
210102	Нэмэгдэл	312,803,683.00	413,891,914.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,264,142.00	41,662,500.00
210104	Урамшуулал	163,479,453.00	115,701,553.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>202,109,291.90</b>	<b>193,430,605.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	141,872,642.11	135,354,746.33
210202	Тэтгэмжийн даатгал	15,112,610.41	14,992,432.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,083,588.33	12,812,683.69
210204	Ажилгүйдлийн даатгал	3,003,559.19	2,837,232.81
210205	Эрүүл мэндийн даатгал	30,036,891.86	27,433,510.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>308,888,745.00</b>	<b>338,272,101.06</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,330,914.00	14,513,303.06
210302	Түлш, халаалт	279,284,187.00	303,813,800.00
210303	Цэвэр, бохир ус	18,273,644.00	19,944,998.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,635,050.00</b>	<b>9,795,135.50</b>
210401	Бичиг хэрэг	850,000.00	1,614,922.00
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	1,044,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	791,670.00	635,853.50
210404	Ном, хэвлэл	597,600.00	210,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,881,000.00	2,627,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,464,780.00	3,662,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,785,270.00</b>	<b>62,133,482.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	731,200.00	962,700.00
210502	Хоол, хүнс	41,791,170.00	57,662,782.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,262,900.00	3,508,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,700,000.00</b>	<b>17,181,710.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,100,300.00
210602	Тавилга	-	516,410.00
210604	Урсгал засвар	1,700,000.00	3,565,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,174,175.00	4,360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,850,175.00	4,360,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,838,500.00	17,917,430.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	3,558,930.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,128,500.00	14,358,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>170,134,793.10</b>	<b>161,656,088.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,714,641.00	58,398,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	163,741.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,175,900.00	55,408,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,375,000.00	2,990,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	135,420,152.10	103,256,788.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	135,420,152.10	103,256,788.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>26,101,270.00</b>	<b>29,426,590.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>26,101,270.00</b>	<b>29,426,590.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,101,270.00</b>	<b>29,426,590.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	26,101,270.00	29,426,590.00
222001	Тоног төхөөрөмж	26,021,270.00	16,328,300.00
223001	Бусад хөрөнгө	80,000.00	13,098,290.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(26,101,270.00)</b>	<b>(29,426,590.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
	Үзүүлэлт	Тайлант оны

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2332089600.00	2223155612.07
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2332089600.00	2223155612.07
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2269440100.00	2165656812.07
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1586862000.00	1510418420.01
210101	Үндсэн цалин	978015300.00	939162452.51
210102	Нэмэгдэл	447691400.00	413891914.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45435000.00	41662500.00
210104	Урамшуулал	115720300.00	115701553.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	213396200.00	193430605.50
210201	Тэтгэврийн даатгал	149921900.00	135354746.33
210202	Тэтгэмжийн даатгал	15702600.00	14992432.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	12860900.00	12812683.69
210204	Ажилгүйдлийн даатгал	3173600.00	2837232.81
210205	Эрүүл мэндийн даатгал	31737200.00	27433510.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	343949300.00	338272101.06
210301	Гэрэл, цахилгаан	14513700.00	14513303.06
210302	Түлш, халаалт	308252300.00	303813800.00
210303	Цэвэр, бохир ус	21183300.00	19944998.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10149500.00	9464773.50
210401	Бичиг хэрэг	941800.00	934560.00
210402	Тээвэр, шатахуун	944100.00	944000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	635,853.50
210404	Ном, хэвлэл	753,900.00	660,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,627,400.00	2,627,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,682,300.00	3,662,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	62,222,800.00	62,133,482.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	962,700.00	962,700.00
210502	Хоол, хүнс	57,630,600.00	57,662,782.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,629,500.00	3,508,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,520,000.00	31,520,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
210602	Тавилга	9,520,000.00	9,520,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	921,800.00	-
210702	Дотоод албан томилолт	921,800.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	160,000.00	160,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,000.00	160,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,258,500.00	20,257,430.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,710,000.00	1,708,930.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,548,500.00	18,548,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	62,649,500.00	57,498,800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	62,649,500.00	57,498,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,435,500.00	55,408,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,214,000.00	2,090,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,332,089,600.00	2,326,412,401.06
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,986,140,300.00	1,986,140,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,986,140,300.00	1,986,140,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	345,949,300.00	340,272,101.06
132001	Орон нутгийн төсвөөс	345,949,300.00	340,272,101.06

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>18,178,662.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>11,328,662.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	10,428,662.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	813,662.00
210401	Бичиг хэрэг	-	713,662.00
210402	Тээвэр, шатахуун	-	100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,565,000.00
210604	Урсгал засвар	-	1,565,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	6,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	1,850,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,850,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	900,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	900,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>6,850,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,850,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,400,000.00
223001	Бусад хөрөнгө	-	4,450,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	18,179,162.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	18,179,162.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,953,662.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,225,500.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хүнсний материал үлдэгдэлтэй гарч нөөц үүсгэсэн, авлага, өглөг үүсгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан, И-баримт түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн үйл ажиллагааны зорилго нь “Сургалтын таатай орчинд хүүхэд бүрийг төрөлх эх орон, Монгол ёс заншлаараа бахархдаг, боловсролтой, хүмүүнлэг иргэн болгон хөгжүүлнэ.” гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгын хэрэгжүүлэхээр дараах зорилтыг тавьж ажилласан байна.

- Багш бүр мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлж “Чадварлаг-бүтээлч багш” байна.
- Ээлжит хичээлийг шинэлэг арга хэлбэрээр зааж, цахим хичээлийн сантай болж суралцагчдыг бүх талаар дэмжин, хоцрогдолыг нөхөн, сурлагын чанарт ахиц гаргах
- Багш суралцагчид харилцан ойлголцсон, эерэг хандлагатай байж монгол ёс заншил, өв уламжлал, амьдрах ухаанд суралцана.
- Сургалтын эрүүл, аюулгүй, таатай, эко орчинг бүрдүүлэх
- Сургууль, багш эцэг эх, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр

нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналт шалгалтын багийг 11 хүний бүрэлдэхүүнтэй томилсон ч тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,148.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 31.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 22.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	30.17	22921.2	22,891.03
Бараа материал	106,387.90	118,016.20	11,628.30
Биет хөрөнгө	4,810,637.30	4,627,144.20	-183,493.10
Биет бус хөрөнгө	479,157.90	485,020.40	5,862.50
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,396,213.3</b>	<b>5,253,102.00</b>	<b>-143,111.3</b>

Өглөг	0	7862.2	7862.2
Хуримтлагдсан үр дүн	2,757,784.10	2,606,810.60	-150,973.50
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,396,213.3</b>	<b>5,253,102.00</b>	<b>-143,111.30</b>

**Авлага:** Өмнөх оноос 22.9 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст Тариатын эхэн ххк-с интернэтийн үйлчилгээ 3.5, Сод электроникс ХХК-иас цахим анги 5.4, Санко маркетинг ХХК-иас ухаалаг дэлгэц 13.0 төгрөгийн худалдан авалт хийхээр гэрээг байгуулж санхүүжилтийг олгосноор авлага үүссэн байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 106.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 118.0 сая төгрөг болж өмнөх оноос 11.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 86.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 84.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 1.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 75.1 сая төгрөгийн бараа материал хасагдсанаас 69.8 сая төгрөг зарцуулж, туслах аж ахуйгаас 5.3 сая төгрөгийг мал худалдаж орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд авсан байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 5714.7 сая, эцсийн үлдэгдэл 5766.9 сая төгрөг болж өмнөх оноос 52.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 29.4, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 22.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Өглөг дансны оны эхний үлдэгдэлгүй оны эцэст 7.9 сая төгрөгийн болж өссөн нь ХХОАТ-ын 12 дугаар сарын төлөлт 7.4, нийгмийн даатгалын шимтгэлийн 0.2, байгууллагад төлөх 0.4 сая төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 2332.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1986.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 345.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1986.1 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 340.3 сая төгрөгийг санхүүжүүлж авч батлагдсан төсвөөс 5.7 сая төгрөгөөр бууруулсан, 2223.2 сая төгрөгийг зарцуулж 103.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2223.2 сая төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 76.4, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 19.9, урсгал шилжүүлэг 5.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас Боловсролын үнэлгээний газраас бичиг хэргийн зардалд 0.2, БСУГ-аас ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 0.5, үнэлгээ хийх бичиг хэргийн зардалд 0.8, 10600000, аймгийн ЗДТГ-аас үндэсний өв бичиг соёлыг дэлгэрүүлэх жилийн аяны зардал 0.9 нийт 12.9, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогод туслах аж ахуйгаа мал худалдсаны орлого 5.2 сая төгрөгийн орлого орж, бичиг хэргийн зардалд 0.7, тээвэр шатахуунд 0.1, урсгал засварт 1.6, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 6.2, бараа үйлчилгээний бусад зардалд 1.8, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 900.0, тоног төхөөрөмж худалдан авахад 6.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

12.9 сая төгрөгийн ариутгал халдвар хамгаалал, бичиг хэргийн зардалд зориулж 394.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 84.2 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулж 310.0 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 4.7 хувиар буюу 103.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт зардлын 1.6 хувь буюу 5.7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зарим дансны үлдэгдэл болон ажил гүйлгээ нь хангалттай зохистой баримтаар нотлогдоогүй тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Аудитаар байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдэл 118.0 сая төгрөгийн хөрөнгийн тооллого хийгдээгүй, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр А/01 тушаалаар тооллого хийсэн гэх боловч анхан шатны баримт материалын бүрдэл дутуу байна. Байгууллага дансанд бүртгэлтэй 5.3 сая төгрөгийн малыг худалдан борлуулж данс бүртгэлээс хассан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар туслах аж ахуйн малын зах зээлд борлуулах үнэ тогтоосон, тухай үнээр худалдаж борлуулсан эсэх, малын тоо толгой зөрүүтэй тодорхой бус байна.

Харилцагч байгууллагуудтай тухай бүр нь тооцоо нийлээгүйгээс авлага, өглөг үүссэн зэрэг зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, тасалбар болголт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 119 мэдээллээс 117 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд төсвөөс 21.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 21.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг холбогдох заалттай нийцээгүй байна.

Өглөг дансны үлдэгдэл НДШ-ийн 0.2, ХХОАТ-ын 7.2, байгууллагад өгөх 0.5 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалттай нийцээгүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Аудитаар нийт 71.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11.7 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 14.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 44.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч хэрэгжилт хангагдсан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого тооцоо, малын хөдөлгөөн өөрчлөлтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 387.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 92.0 сая төгрөгийн алдааг залруулж, 161.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 133.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

#### **4.1 Залруулсан алдаа**

- Бусад үндсэн хөрөнгө дансны тайлант оны элэгдлийг 3419213, барилга байгууламжийн элэгдлийг 59533890.48 төгрөгөөр дутуу тооцоосон нь Төсвийн байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл 4.35-д “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийг шимтгэлийн зардал хүлээн зөвшөөрнө” заалтыг зөрчсөн аудитын явцад залруулга хийсэн.
- ХХОАТ-ийн 7207273 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүйг нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах

зүйлсийг заавал бүртгэнэ:", "14.4.3.бүх өр төлбөр," гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг аудитын явцад залруулга хийсэн.

- Оны эцэст 21912600 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүссэн байхад бүртгээгүй байна. НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйг аудитын явцад залруулга хийсэн.

#### 4.2 Төлбөрийн акт: Байхгүй.

#### 4.3 Албан шаардлага

- Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангаар бараа материалын үлдэгдэл 118.0 төгрөгийн хөрөнгийн тооллого хийгдээгүй, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр А/01 тушаалаар тооллого хийсэн гэх боловч анхан шатны баримт материалын бүрдэл дутуу байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
- Байгууллага дансанд бүртгэлтэй 5.3 сая төгрөгийн малыг худалдан борлуулж данс бүртгэлээс хассан байна. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар туслах аж ахуйн малын зах зээлд борлуулах үнэ тогтоосон, тухай үнээр худалдаж борлуулсан эсэх, малын тоо толгой зөрүүтэй тодорхой бус зөрчилд албан шаардлага өгсөн.
- Тайлант онд төсвөөс 21.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 21.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас шүүхийн шийдвэрийн дагуу ажлаас халагдсан сургалтын менежер ажилтай Б.Нандин-эрдэнэ 2021 оны 09 дүгээр сарын 01-нээс 30-ны ажилгүй байх хугацааны нийт 1137647/Нэг сая нэг зуун гучин долоон мянга зургаан зуун дөчин долоон/ төгрөгийн цалинг байгууллагаас төлж, буруутай албан тушаалтнаар байгууллагын хохирлыг барагдуулаагүй байна. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалтуудын дагуу албан шаардлага өгсөн.

#### 4.4 Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

##### 1. Зардлын данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 6.2 сая төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар

зүйл 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалт хийхдээ тухай бүр нь цахим И-баримтыг хангуулан бүртгэлд тусгаж байх.

**2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой**

**3.1 Илрүүлэлт:**

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 99 төрлийн 104.5 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй, данс бүртгэлээс хасаагүй тайланд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

**3. Авлаг, өглөгийн данстай холбоотой**

**3.1 Илрүүлэлт:**

Харилцагч нартай тухай бүр тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс НДШ-ийн 192824, ХХОАТ-ын 7207273, байгууллагад өгөх 462090 төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Харилцагч байгууллагуудтай тухай бүр тооцоо нийлж баталгаажуулан авлага, өглөг үүсгэхгүй ажиллах.

**4. Дотоод хяналттай холбоотой**

**3.1 Илрүүлэлт** Дотоод хяналт шалгалтын багийг 11 хүний бүрэлдэхүүнтэй томилсон ч тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтын журам боловсруулж, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн